



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 1/82

Улаанбаатар хот

Статистикийн төв, орон нутгийн байгууллагын
ажилтнуудын сургалтын хөтөлбөрийг
зөвшөөрөх тухай

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 12-ын 3 дахь хэсгийн 13-р зүйлийг үндэслэн ТУШААХ нь :

Нэг. Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын сургалтын хөтөлбөрийг хавсралтаар зөвшөөрсүгэй.

Хоёр. ҮСХ-ны хэрэгцээ, шаардлагыг үндэслэн сургалтын хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх түшиц сургуулиар МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг сонгох нь зүйтэй гэж үзэж хамтран ажиллах гэрээ байгуулсугай.

Гурав. Хорооны Ерөнхий менежер /Б.Ганбат/-т үүрэг болгох нь:

3.1. Сургалтын хөтөлбөрийг МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Сургалтын албаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

3.2. Хөтөлбөрийн дагуу сургалтыг явуулах графикчилсан төлөвлөгөөг МУИС-ийн Эдийн засгийн сургуультай хамтран боловсруулж мөрдөх.

3.3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлын тооцоог 2013-2015 оноор нарийвчлан гаргаж, 2013 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусгуулж байх.

3.4. Сургалт зохион байгуулахтай холбогдон 2012 онд шаардагдах зардлын тооцоог нарийвчлан хянаж, холбогдох зардлыг гаргах.


Дөрөв. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Б.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА



С.МЭНДСАЙХАН

ҮСХ-ны даргын 2012 оны 07 сарын 07-ны
өдрийн 1/82 тоот тушаалын хавсралт



СТАТИСТИКИЙН ТӨВ, ОРОН НУТГИЙН
БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Улаанбаатар хот
2012 оны 06 дугаар сарын 22

АГУУЛГА

БҮЛЭГ I	УДИРТГАЛ	
1.1	Байгууллагын танилцуулга	
1.2	Хүний нөөцийн бодлого, стратеги	
БҮЛЭГ II	СУРГАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ	
2.1	Сургалтын хэрэгцээ шаардлага	
2.2	Сургалтын зорилт	
2.3	Сургалтын төрөл, шатлал	
2.4	Сургалт явуулах хугацаа	
2.5	Сургалтын үнэлгээ	
2.6	Шалгалтын хэлбэр	
2.7	Сургалтын дүйцүүлэх хэлбэр	
БҮЛЭГ III	СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	
	Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт	
3.1	ҮСХ-ны ажилтнуудад зориулсан сургалт (нийслэлийн статистикийн газар, дүүргийн статистикийн хэлтсийн ажилтнуудыг оруулаад)	
	3.1.1 Анхан шатны сургалтын модуль	
	3.1.2 Дунд түвшний 1-р шатны сургалтын модуль	
	3.1.3 Дунд түвшний 2-р шатны сургалтын модуль	

	3.1.4	Ахисан түвшний сургалтын модуль	
	3.1.5	Англи хэлний сургалт	
3.2	Орон нутгийн статистикийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт		
	3.2.1	Анхан шатны сургалт	
	3.2.2	Дунд шатны сургалт	
БҮЛЭГ IV	СУРГАЛТ ЯВУУЛАХ БАЙГУУЛЛАГА		

БҮЛЭГ 1: УДИРТГАЛ

1.1. Байгууллагын танилцуулга

Монгол Улсын статистикийн салбар нь төвлөрсөн шинж зонхилсон холимог тогтолцоотой бөгөөд Үндэсний статистикийн хороо (ҮСХ), яам, агентлагийн статистикийн нэгж, нийслэл, аймаг, дүүргийн Засаг даргын дэргэдэх статистикийн газар, хэлтэс, сум, баг, хорооны статистикийн асуудал хариуцсан ажилтнуудаар үйл ажиллагаа нь явагддаг.

ҮСХ нь статистикийн үйл ажиллагааг нэгдсэн арга зүй, мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах, мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах үндсэн чиг үүрэгтэй. ҮСХ-ны дэргэд даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд туслах, зөвлөх үүрэгтэй Даргын зөвлөл, статистикийн мэдээ мэдээллийн чанарыг сайжруулах, судалгаа, шинжилгээний арга зүй, аргачлал зааврыг боловсронгуй болгох чиг үүрэгтэй Арга зүйн байнгын зөвлөл ажилладаг.

Албан ёсны статистикийн үйл ажиллагааг явуулахад туслах, арга зүйн нэгдмэл байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий төрийн байгууллага, эрдэмтэд, судлаачид, хэрэглэгчийн төлөөллөөс бүрдсэн ҮСХ-ны Зөвлөл тусгай үүрэгтэйгээр ажилладаг.

УИХ-аар ҮСХ нь 2011 онд “Монгол Улсын Статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулсан бөгөөд уг хөтөлбөр нь Монгол Улсын статистикийн салбарыг хөгжүүлэх зорилго, зорилт, бодлого, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт, санхүүжилт болон хүрэх үр дүнг тодорхойлсон.

1.2. Хүний нөөцийн бодлого, стратеги

Статистикийн албыг бэхжүүлэх нэг үндсэн нөхцөл нь тус салбарын тусгай мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх, бэлтгэх, сургах явдал юм.

ҮСХ нь хүний нөөцийнхөө мэдлэг, чадварыг байнга дээшлүүлж, албан тушаалын зэрэг дэвийг нэмэгдүүлэх замаар байгууллагынхаа чадавхийг бэхжүүлэх, гадаад дотоодод бэлтгэгдсэн хүний нөөцийг ажил дээр нь байнга сургаж дадлагажуулах, гадаад, дотоодод урт, богино хугацаагаар сургалтад хамруулах, дадлага хийлгэх ажлыг системтэй зохион байгуулсаар ирсэн.

Салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр нэлээд арга хэмжээ авсны үндсэн дээр ахиц гарч байгаа хэдий ч мэргэшсэн боловсон хүчний хангамж дутагдалтай, ажилтнуудыг дадлагажуулах, давтан сургах, мэргэшүүлэх, чадваржуулах шаардлага зүй ёсоор дэвшигдсээр байна.

“Монгол Улсын Статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан нэг зорилт нь “Статистикийн салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх” тухай бөгөөд үүнд, “Салбарын ажилтнуудыг сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх замаар ажиллагчдын чадавхийг дээшлүүлж, мэргэжлийн ур чадвартай

хүний нөөцийг бэхжүүлнэ” гэж заасан юм. Энэхүү зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Ажилтнуудын хэлний болон мэргэжлийн чадавхийг сайжруулж өндөр хөгжилтэй орны магистрантур, докторантурын сургалтад хамруулах боломжийг нэмэгдүүлэх;
- Тодорхой бодлого, чиглэлээр ажилтныг мэргэшүүлэх, дадлагажуулах ажлыг өргөжүүлэх;
- Ажилтны мэргэшлийн ур чадварыг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх идэвхийг нэмэгдүүлэх;
- Залуу ажилтны гадаад хэлний мэдлэгийг дундаас дээш түвшинд хүргэж, олон улсын хурал, сургалтад оролцох, интернет болон бусад эх үүсвэрээс мэргэжлийн ном, материал, гарын авлага ашиглах чадавхийг дээшлүүлэх.

Мөн хүний нөөцийн чадавхийг тасралтгүй сайжруулах сургалтын үйл ажиллагааг зохистой зохион байгуулах үүднээс “Ажилтны сургалтын баазыг өргөтгөх, чадавхижуулах” дэд зорилт тавьсан бөгөөд уг зорилтын хүрээнд сургалтын танхимыг өргөтгөж сургалт, мэдээлэл, сурталчилгааны төв болгох, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгож, багшлах боловсон хүчин, сургагч нарыг бэлтгэх, статистикийн системийн ажилтнуудыг сургах, давтан сургах, мэргэшүүлэх ажлыг өөрийн сургалтын төвөөр хэрэгжүүлэх, статистикийн мэдээлэгч, хэрэглэгч нарт зориулсан сургалт, семинарыг зохион байгуулах зэрэг олон арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх юм.

Дэлхийн банкны хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд “МОНСТАТ: Монгол Улсын үндэсний статистикийн системийг бэхжүүлэх” төсөл ҮСХ-нд 2010 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг төслийн хүрээнд а) статистикийн салбарын хүний нөөцийн нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хүний нөөцийн удирдлагын системийг сайжруулах, хүний нөөцийн зохистой менежментийг хэрэгжүүлэх, б) статистикийн системийн хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх, мэргэшсэн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах үндсэн 2 зорилт тавигдсан юм. МОНСТАТ төслийн үйл ажиллагааны хүрээнд статистикийн салбарын хүний нөөц, чадавхийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, салбарын хэмжээнд тавигдсан зорилтод нийцүүлэн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх хөтөлбөр батлуулж хэрэгжүүлэх, боловсон хүчнийг мэргэшүүлэх хэрэгцээ, сургалтын стратегийг тодорхойлж, сургаж дадлагажуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, орон нутгийн ажилтнуудад зориулсан он-лайн сургалтын модуль боловсруулах, статистикийн сургалтын төвтэй болж, сургалт хариуцсан нэгжийг ҮСХ-нд бий болгох, салбарын ажилтнуудыг хөгжингүй орнуудын статистикийн байгууллагын туршлагыг судлах, мэргэжил дээшлүүлэх зорилгоор томилон ажиллуулж, ажлын байранд сургах зэрэг олон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхлээд байгаа юм.

БҮЛЭГ 2: СУРГАЛТЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

2.1. Сургалтын хэрэгцээ, шаардлага

Үндэсний статистикийн салбарын хэмжээнд 2011 оны байдлаар 289 ажиллагчид ажиллаж байгаагаас ҮСХ-нд 109 хүн, орон нутгийн статистикийн газар, хэлтэст 180 хүн байна. Нийт ажилтнуудын 59.2 хувь 10 хүртэлх жил ажиллаж байгаа бол 15.3 хувь нь

26-гаас дээш жил төрийн албанд ажиллаж байна. Салбарт ажиллагчдын 80.0 хувь нь бакалаврын боловсролтой, 17.6 хувь нь магистр, 2.4 хувь нь доктор байна. Нийт ажилтнуудын 56.1 хувийг 21-35 насны залуучууд эзэлж байна.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 4 дүгээр бүлгийн 11 дүгээр зүйлийн 6-д “Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагаа эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна” гэж заасан.

Өнөөгийн байдлаар яам, газруудад статистикийн асуудал хариуцсан тусгай нэгж байхгүй байгаа бөгөөд мэдээлэл, хяналт, үнэлгээ, мониторингийн газар, хэлтсүүдэд статистикийн мэдээ, тайлан хариуцан ажиллаж байгаа цөөн тооны ажилтан байна.

Монгол Улсын 11 яам, тэдгээрийн харьяа агентлагуудад статистикийн мэдээ, тайлан хариуцан ажиллаж буй нэгж, тэдгээрийн ажилтнуудын судалгааг нэгтгэхэд нийтдээ 112 хүн ажиллаж байгаагийн 32 нь нягтлан бодогч, эдийн засагч, статистикч мэргэжилтэй байгаа нь нийт ажилтнуудын 28.6 хувийг эзэлж байна.

Бусад ажилтнуудын хувьд тухайн яам, агентлагийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн хүмүүс ажиллаж байна.

Салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр нэлээд арга хэмжээ авсны үр дүнд гарч байгаа ба ҮСХ-ны хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэхэд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй МОНСТАТ төсөл ихээхэн хувь нэмэр оруулж байна. Тус төслийн хүрээнд техникийн зөвлөгөө, экспертийн дүн шинжилгээний дэмжлэг болон практик зөвлөгөө өгөх, дотоод, гадаад сургалт, зарим улс, орнуудын статистикийн тогтолцоог (ХБНГУ-ын DeStatis, БНСУ-ын Статистикийн сургалтын институт гэх мэт) судлах, танилцах аялал зохион байгуулах ажлыг зохион байгуулсан нь ихээхэн ач холбогдлоо өгч байна. Цаашид энэ төрлийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулж үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ҮСХ статистикийн салбарын ажилтнуудад зориулсан иж бүрэн сургалтын хөтөлбөртэй болох шаардлагатай байгаа бөгөөд уг сургалтын хөтөлбөрт мэргэжлийн, мэдээлэл технологийн, удирдлагын арга зүйн чиглэлийн агуулга бүхий хичээлүүдийг оруулж байна. Энэхүү сургалтын хөтөлбөрийг олон улсын нийтлэг жишиг стандарт болсон хөтөлбөрүүдэд, тухайлбал, Европын холбооны ЕвроСтат сургалтын хөтөлбөр, Их Британы Хатан хааны статистикийн нийгэмлэгийн сургалт, Канадын статистикийн сургалт, ХБНГУ-ын DeStatis-ийн ахисан түвшний сургалтын хөтөлбөр, КОСТАТ-ийн сургалтын хөтөлбөрүүдийг судалсны үндсэн дээр боловсруулсан ба эдгээр улсын сургалтын хөтөлбөрүүд нь ажилтнуудыг албан тушаалын бүх шатлалд тасралтгүй суралцах боломжийг олгох зорилготой байдаг аж.

Европын холбооны ЕвроСтат сургалтын хөтөлбөр нь албан ёсны статистик, мэдээлэл технологи, судалгаа ба хөгжил, статистикийн удирдлага зэрэг үндсэн 4 чиглэлийн хичээлүүдийг санал болгодог. Энэхүү сургалтын хөтөлбөрийн гол зорилго нь Европын болон олон улсын ахисан түвшний сургалтуудад оролцох боломжийг олгох замаар Европын статистикчдын мэргэшүүлэх сургалтыг өргөжүүлэх явдал юм.

Хатан хааны статистикийн нийгэмлэг нь анхан, дунд, ахисан түвшний сургалтуудыг зохион байгуулдаг. Сургалтын түвшин бүрт ялгаатай модулиар сургалтаа явуулдаг.

Эдгээр сургалт нь статистикийн байгууллагад ажилд орохыг хүссэн хэн бүхэнд нээлттэйгээс гадна статистикийн ажилтнуудын албан тушаал ахих, мэргэжил дээшлүүлэх боломжийг олгодог. Мөн эдгээр сургалт нь өөр салбараас статистикийн салбарт шилжин ажиллах хүсэлтэй хүмүүст, статистикийн сургалтгүй болон бага зэргийн сургалт явуулдаг гадаад орныхонд болон статистикийн мэргэжлийн цөөн тооны мэргэшсэн хүний нөөцтэй байгууллагуудад ихээхэн тус нэмэр болохуйц хөтөлбөртэй.

Канадын статистик нь өөрийн гэсэн өвөрмөц, иж бүрдэл бүхий сургалтын хөтөлбөртэй. Сургалт нь анхан шатны, янз бүрийн сонголт бүхий мэргэжлийн, удирдлагын зэрэг төрөл бүрийн түвшинтэй байна.

КОСТАТ янз бүрийн түвшин бүхий сургалтын хөтөлбөртэй бөгөөд энэхүү сургалтын хөтөлбөрөөр КОСТАТ-ийн ажилтнуудад, статистиктай холбоотой бусад байгууллагуудад болон нийт иргэдэд зориулсан сургалт явуулдаг. Сургалтын хөтөлбөрийн гол зорилго нь статистикийн байгууллагын ажилтнуудын онолын болон практик мэдлэг, чадварыг дээшлүүлэх, олон нийтийн статистикийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, статистикийг хэрэглэх ур чадварыг эзэмшүүлэх явдал юм.

ХБНГУ-ын DeStatis нь ахисан түвшний сургалтын хөтөлбөртэй. Энэхүү хөтөлбөр нь ерөнхий статистик, статистик мэдээллийн чанар, мэдээллийн технологи, хууль эрх зүй, тоо мэдээлэл хамгаалалт, нууцлалт, аюулгүй байдал, хэлний зэрэг олон чиглэлүүдтэй.

Дээр дурдсан сургалтын хөтөлбөрүүдэд үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

2.2 Сургалтын зорилт

Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалтын бодлогын үндсэн зорилт нь статистикийн ажилтнуудыг ажилд анх орохоос эхлэн албан тушаалын шатлал бүрт жигд сургалтад хамруулж, мэдлэг ур чадвараа системтэй дээшлүүлж, албан тушаалын шатлал ахиж ажиллах үндсэн нөхцөлийг хангахад чиглэгдэнэ.

2.3 Сургалтын төрөл, шатлал

Сургалтын төрөл:

2.3.1 ҮСХ-ны ажилтнуудад зориулсан сургалт (нийслэлийн статистикийн газар, дүүргийн статистикийн хэлтсийн ажилтнуудыг оруулаад)

2.3.1.1 **Анхан шатны сургалт:** Үндэсний статистикийн систем, ҮСХ, орон нутгийн статистикийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, статистикийн үйл ажиллагааны технологийн үе шатны талаар танилцуулах, мэдээлэл цуглуулах, боловсруулах,

шинжлэх, тайлбарлах чадвартай болгох, ҮТС, эдийн засгийн болон хүн ам, нийгмийн статистикийн суурь мэдлэг олгох, статистикийн хэрэглээний программын талаар үндсэн ойлголттой болох, үзүүлэлтүүдийг программд тодорхойлж, тайлбар дүгнэлт өгөх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

Тавигдах шаардлага: Статистикийн байгууллагад шинээр ажилд орж байгаа мэргэжилтэн, шинжээч нар хамрагдана. Анхан шатны сертификат олгогдоно.

2.3.1.2 **Дунд түвшний 1-р шатны сургалт:** Мэдээлэл цуглуулах, боловсруулах, шинжлэх, тайлбарлах чадвартай болгох, түүврийн арга зүй, ҮТС болон салбарын статистикийн холбогдох сэдвүүд, эконометрикийн суурь ойлголтыг судлах, статистикийн хэрэглээний программд холбогдох үзүүлэлтүүдийг тооцоолж үндсэн тайлбар, дүгнэлт өгөх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

Тавигдах шаардлага: Анхан шатны сургалтад хамрагдаж сертификат авсан байна.

Нэмэлт: Зарим сэдвийг англи хэлээр заана.

Дунд түвшний 1-р шатны сертификат олгогдоно.

2.3.1.3 **Дунд түвшний 2-р шатны сургалт:** Статистикийн онолын холбогдох сэдвүүд, өрхөд болон аж ахуйн нэгжид суурилсан түүврийн дизайн, дунд түвшний эконометрикийн зарим асуудлууд, ҮТС, эдийн засгийн болон хүн ам, нийгмийн статистик, олон хэмжээст статистикийн үндсэн асуудлыг судлах, статистикийн хэрэглээний программд холбогдох тооцоог гүйцэтгэж тайлбар, дүгнэлтийг бүрэн дүүрэн өгөх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

Тавигдах шаардлага: Дунд түвшний 1-р шатны сургалтад хамрагдаж сертификат авсан байна.

Нэмэлт: Зарим сэдвийг англи хэлээр заана.

Дунд түвшний 2-р шатны сертификат олгогдоно.

2.3.1.4 **Ахисан түвшний сургалт:** Олон хэмжээст статистик, дунд түвшний эконометрик шинжилгээ, ҮТС, эдийн засгийн болон хүн ам, нийгмийн статистикийн үндсэн асуудлууд, мэдээлэл технологийн хэрэглээг судлах, статистикийн хэрэглээний программд холбогдох тооцоог гүйцэтгэж, үндэслэл бүхий тайлбар, дүгнэлт өгөх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

Тавигдах шаардлага: Дунд түвшний 2-р шатны сургалтад хамрагдаж сертификат авсан байна.

Ахисан түвшний тусгай сертификат олгогдоно.

2.3.1.5 **Англи хэлний сургалт:** Энэ сургалтыг тусгай хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.

2.3.2 Орон нутгийн статистикийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт

2.3.2.1 Анхан шатны сургалт: Үндэсний статистикийн систем, ҮСХ, орон нутгийн статистикийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, статистикийн үйл ажиллагааны технологийн үе шатны талаар танилцуулах, мэдээлэл цуглуулах, боловсруулах, шинжлэх, тайлбарлах чадвартай болгох, ҮТС, салбарын статистикийн суурь мэдлэг олгох, статистикийн хэрэглээний программын талаар үндсэн ойлголттой болох, үзүүлэлтүүдийг программд тодорхойлж, тайлбар дүгнэлт өгөх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

2.3.2.2 Дунд шатны сургалт: Мэдээлэл цуглуулах, боловсруулах, шинжлэх, тайлбарлах чадвартай болгох, түүврийн оновчтой хэмжээг тодорхойлох, түүврийн үр дүнг эх олонлогт тархаах, ҮТС болон салбарын статистикийн холбогдох сэдвүүд, статистикийн хэрэглээний программд холбогдох үзүүлэлтүүдийг тооцоолж үндсэн тайлбар, дүгнэлт өгөх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын сургалтаар судлах хичээл, кредитыг хавсралтаар үзүүлэв.

Сургалтын шатлал:

Сургалтад хамрагдах ажилтнуудын ангиллыг тогтооходоо албан тушаалын шатлал, бүтээгдэхүүн үйлчилгээг гаргахад оролцож буй технологийн дамжлага, дотроо сэлгэн ажиллах шаардлага зэргийг харгалзан дараах 4 ангилалд хуваана.

Үүнд:

1. Захиргаа, үйлчилгээний ажилтнууд /ТГ, ГХХАГ/
 2. Нэгдсэн тооцоо, аргачлал, шинжилгээ, судалгаа, салбарын статистикийн мэдээлэл хариуцсан ажилтнууд /МЭЗСГ, ШСГ, ХАНСГ/
 3. Мэдээлэл боловсруулалт, технологийн асуудал хариуцсан ажилтнууд /МБТГ/
 4. Орон нутгийн статистикийн байгууллагын ажилтнууд
- ҮСХ-ны ажилтнуудын сургалтын шатлалын хувьд албан тушаалын мэргэжилтэн, шинжээч, ахлах шинжээч, статистикч гэсэн зэрэглэлд тавигдах ажлын байрны шаардлагад нийцүүлэн сургалтын төрлийг тодорхойлсон болно.

Нийслэлийн статистикийн газар, дүүргийн статистикийн хэлтсийн ажилтнууд дээрх 4 ангиллын 2 дахь ангиллын мэргэжилтэн, шинжээч шатлалд хамаарагдана.

2.3 Сургалт явуулах хугацаа

ҮСХ-ны ажилтнуудын хувьд МУИС-ийн ЭЗС-тай хамтран баталсан календарьчилсан төлөвлөгөөний дагуу сургалтад хамрагдана. Мөн энэ сургалтад нийслэл, дүүргийн статистикийн газар, хэлтсийн ажилтнууд хамрагдана.

Харин аймгийн статистикийн хэлтсийн ажилтнуудын чиглүүлэх сургалтыг хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн заана. Бусад сургалтыг нэгдсэн болон бүсчилсэн сургалтад хамруулах, он-лайн хэлбэрээр явуулна.

2.4 Сургалтын үнэлгээ

Дээр дурдсан сургалтын төрлөөр энгийн сертификат, дунд түвшний 2-р зэргийн сертификат, дунд түвшний 1-р түвшний сертификат, ахисан түвшний сертификат олгогдоно. Анхан шатны сургалтыг 7 модультайгаар, дунд түвшний 1-р шатны сургалтыг 9 модультайгаар, дунд түвшний 2-р шатны сургалтыг 10 модультайгаар, ахисан түвшний сургалтыг 9 модультайгаар, орон нутгийн статистикийн байгууллагын ажилтнуудад зориулсан анхан шатны сургалтыг 4 модультайгаар, дунд шатны сургалтыг 5 модультайгаар явуулж холбогдох шалгалтаар баталгаажуулна.

2.6 Шалгалтын хэлбэр

Сургалтын төрлөөс хамааран сургалт явуулсан багш, ҮСХ-ноос томилогдсон ажилтнууд хамтран шалгалт авах ба шалгалт нь сургалтын төрөл болон онцлогоос хамааран тестийн, бичгийн, бодлогын, практик асуудал бүхий хэлбэртэй, мөн эдгээрийн хосолсон хэлбэртэй байж болно.

2.7 Сургалтын дүйцүүлэх хэлбэр

Гадаад, дотоодын их дээд сургуульд магистр, докторын зэрэг хамгаалсан нөхцөлд тухайн сургалтыг дараах хэлбэрээр дүйцүүлэн тооцно.

Үүнд:

Гадаадын болон дотоодын их дээд сургуульд эдийн засгийн салбараар докторын зэрэг хамгаалсан нөхцөлд АХИСАН ТҮВШНИЙ СУРГАЛТ-тай

Гадаадын болон дотоодын их, дээд сургуульд бизнес удирдлагын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан нөхцөлд ДУНД ТҮВШНИЙ 2-Р ШАТНЫ СУРГАЛТ-тай

Гадаадын их, дээд сургуульд эдийн засгийн салбараар магистрын зэрэг хамгаалсан нөхцөлд ДУНД ТҮВШНИЙ 2-Р ШАТНЫ СУРГАЛТ-тай

Гадаадын их, дээд сургуульд бизнес удирдлагын салбараар магистрын зэрэг хамгаалсан нөхцөлд ДУНД ТҮВШНИЙ 1-Р ШАТНЫ СУРГАЛТ-тай

Дотоодын их, дээд сургуульд эдийн засгийн салбараар магистрын зэрэг хамгаалсан нөхцөлд ДУНД ТҮВШНИЙ 1-Р ШАТНЫ СУРГАЛТ-тай

Дотоодын их, дээд сургуульд бизнес удирдлагын салбараар магистрын зэрэг хамгаалсан нөхцөлд ЭНГИЙН ТҮВШНИЙ СУРГАЛТ-тай дүйцүүлнэ.

Статистикийн төв болон орон нутгийн байгууллагын ажилтнуудыг гадаад сургалтад хамруулах тохиолдолд холбогдох кредитыг дүйцүүлэн тооцно.

БҮЛЭГ 3: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Статистикийн төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт

3.1 ҮСХ-ны ажилтнуудад зориулсан сургалт

3.1.1 Анхан шатны сургалт

Үндэсний статистикийн систем, ҮСХ, орон нутгийн статистикийн байгууллагын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, статистикийн үйл ажиллагааны технологийн үе шатны талаар танилцуулах, мэдээлэл цуглуулах, боловсруулах, шинжлэх, тайлбарлах чадвартай болгох, ҮТС, эдийн засгийн болон хүн ам, нийгмийн статистикийн суурь мэдлэг олгох, статистикийн хэрэглээний программын талаар үндсэн ойлголттой болох, үзүүлэлтүүдийг программд тодорхойлж, тайлбар дүгнэлт өгөх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

Тавигдах шаардлага: Статистикийн байгууллагад шинээр ажилд орж байгаа мэргэжилтэн, шинжээч нар хамрагдана. Анхан шатны сертификат олгогдоно.

Модуль 1: Статистикийн байгууллагад шинээр ажилд орж буй ажилтнуудад зориулсан сургалт			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Үндэсний статистикийн систем	Үндэсний статистикийн систем, ҮСХ болон орон нутгийн статистикийн албаны бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг	1	
Монгол Улсын “Статистикийн тухай” хууль, “Хүн ам орон сууцны тухай” хууль	Хуулийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа	1	
Ажлын байранд ашиглагдах бусад хууль журам	Хөдөлмөрийн хууль, нууцын тухай хуулиуд, төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх, төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм	3	
Статистикийн үйл ажиллагааны технологи	Тооллого судалгааны болон статистикийн графикт	2	

	мэдээллийг цуглуулах, боловсруулах, нэгтгэх үйл ажиллагаа, хуульд заасан тооллого, судалгаа		
Байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолт	Тухайн ажлын байранд тавигдах нийтлэг шаардлага, гүйцэтгэх ажил үүрэг	1	
Нийт		8	
Модуль 2: Мэдээлэл цуглуулах, боловсруулах, шинжлэх, тайлбарлах			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Статистикийн үзүүлэлтүүд	Абсолют үзүүлэлт, харьцангуй үзүүлэлт, дундаж үзүүлэлт, бүтцийн дундаж хэмжигдэхүүн	2	2
Мэдээллийг хүснэгт графикаар илэрхийлэх	Бүлэглэх, хүснэгт болон графикаар илэрхийлэх	1	2
Хэлбэлзлийн үзүүлэлтүүд	Хэлбэлзлийн далайц, вариацийн коэффициент, шугаман ба квадрат дундаж хэлбэлзэл, дисперс	2	2
Хамаарал, чиг хандлагыг тодорхойлох	Нийгэм-эдийн засгийн үзэгдлүүдийн хамаарлын статистик судалгаа, динамик эгнээ, түүний үндсэн үзүүлэлтүүд, динамик эгнээг тэгшитгэх, индексийн шинжилгээ	7	6
Нийт		12	12

Модуль 3: Үндэсний тооцооны систем			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
ҮТС-ийн тухай суурь мэдлэг	ҮТС-ийн онолын тулгуур үзэл баримтлал	1	1
	ҮТС-ийн үндсэн ойлголт, ашиглагдах ангилал	1	1
Нийт		2	2

Модуль 4: Эдийн засгийн статистик
--

Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
ХАА	Мал аж ахуйн статистикийн үзүүлэлтүүдийг (нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртөг, завсрын хэрэглээ зэрэг) тооцох, сүргийн нөхөн үйлдвэрлэл, сүргийн эргэлтийн баланс, малын ашиг шимийн бүтээгдэхүүн	1	1
Аж үйлдвэр	Аж үйлдвэрийн салбарын ангилалт, ойлголт, ажиглалтын нэгж, тэдгээрийн тодорхойлолт, аж үйлдвэрийн газрын нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртөг, завсрын хэрэглээг тодорхойлох	1	1
Барилга, тээвэр, холбоо	Барилга, тээвэр, холбоо, худалдааны салбарын нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн статистик үзүүлэлтүүд	2	1
Нийт		4	3

Модуль 5: Хүн ам, нийгмийн статистик			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Хүн ам	Хүн амын тоо бүрэлдэхүүн, ердийн ба механик хөдөлгөөний статистик	1	1
Хөдөлмөрийн зах зээл	Хөдөлмөрийн зах зээлийн статистик: хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсний статистик	1	1
Ядуурлын статистик	ДНБ-ий хэрэглээ, хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын статистикийн үзүүлэлтүүд	2	

Хүний хөгжлийн статистик	Хүний хөгжлийн үзэл баримтлал, хэмжигдэхүүн, хүний хөгжлийн индекс тооцох	1	1
Нийт		5	3

Модуль 6: Статистикийн хэрэглээний программ			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Удиртгал	MS Excel программын талаарх ойлголт, ачаалах, программын бүтэц	1	1
MS Excel	MS Excel программын нийтлэг хэрэглэгддэг функцуудыг судлах	1	1
Нийт		2	2

Модуль 7: Мэдээлэл технологийн мэдлэг			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Мэдээллийн технологи	Үндсэн ойлголт, тодорхойлолт		2
Техник болон программ хангамж	Компьютерийн техник хангамж, ангилал үүрэг, хөгжлийн чиг хандлага	2	2
Нийт		2	4

Модуль1 – Модуль7 шалгалтад тэнцсэн тохиолдолд статистикийн анхан шатны сургалтыг дүүргэсэн гэж үзэж **ЭНГИЙН СЕРТИФИКАТ** олгоно.

3.1.2 Дунд түвшний 1-р шатны сургалт

Дунд түвшний 1-р шатны сургалт:

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, шинжлэх, тайлбарлах чадвартай болгох, түүврийн арга зүй, ҮТС болон салбарын статистикийн холбогдох сэдвүүд, эконометрикийн суурь

ойлголтыг судлах, статистикийн хэрэглээний программд холбогдох үзүүлэлтүүдийг тооцоолж үндсэн тайлбар, дүгнэлт өгөх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

Тавигдах шаардлага: Анхан шатны сургалтад хамрагдаж сертификат авсан байна.

Модуль 1: Мэдээлэл цуглуулах, боловсруулах, шинжлэх, тайлбарлах			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Статистикийн үзүүлэлтүүд	Абсолют үзүүлэлт, харьцангуй үзүүлэлт, дундаж үзүүлэлт, бүтцийн дундаж хэмжигдэхүүн	3	2
Мэдээллийг хүснэгт графикаар илэрхийлэх	Бүлэглэх, хүснэгт болон графикаар илэрхийлэх	1	1
Хэлбэлзлийн үзүүлэлтүүд	Хэлбэлзлийн далайц, вариацийн коэффициент, шугаман ба квадрат дундаж хэлбэлзэл, дисперс	2	2
Хамаарал, чиг хандлагыг тодорхойлох	Нийгэм-эдийн засгийн үзэгдлүүдийн хамаарлын статистик судалгаа, динамик эгнээ, түүний үндсэн үзүүлэлтүүд, динамик эгнээг тэгшитгэх, индексийн шинжилгээ	6	3
Түүврийн арга зүй	Түүврийн оновчтой хэмжээг тодорхойлох, түүврийн үр дүнг эх олонлогт тархаах	2	2
Нийт		14	10

Модуль 2: Эконометрикийн үндэс			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Шугаман регрессийн загвар	Хоёр хувьсагчийн шугаман регрессийн загвар, ХБКҮ-ний аргын урьдчилсан нөхцөл, ХБКҮ-ний стандарт алдаа	1	1
	Детерминацийн коэффициент, Шугаман регрессийн сонгодог загвар: Нормаль байх нөхцөл	1	1
Нийт		2	2

Модуль 3: Дунд түвшний эконометрик			
Сэдэв	Тайлбар	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Эконометрик загвар	Цаг хугацааны эконометрик: Хэтийн тооцоо хийх	2	2
Нийт		2	2

Модуль 4: Үндэсний тооцооны систем			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
ҮТС-ийн суурь мэдлэг	ҮТС-ийн онолын тулгуур үзэл баримтлал	1	1
	ҮТС-ийн үндсэн ойлголт, ашиглагдах ангилал	1	1
ДНБ	ДНБ-ийг тооцох 3 арга, нийт үйлдвэрлэлийг салбарын онцлогтой тооцох аргууд	1	1
	Макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг зэрэгцүүлэх үнээр тооцох аргууд	1	
Үндэсний тооцооны данс	ҮТС-ийн үндсэн үзүүлэлтүүд, тооцох арга зүй, үзүүлэлт хоорондын уялдаа холбоо	1	
	Үндэсний тооцооны нэгдсэн данснууд, байгуулах зарчим, арга зүй, дотоод болон гадаад эдийн засгийн сектороор	1	1
Нийт		6	4

Модуль 5: Эдийн засгийн статистик			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
ХАА	Газрын фонд, түүний ашиглалтын статистикийн үзүүлэлтүүд, газрын фондын	1	1

	ангилал, бүтэц бүрэлдэхүүний талаарх ойлголт		
	Газар тариалангийн статистик	1	
	Мал аж ахуйн статистикийн үзүүлэлтүүдийг тооцох, сүргийн нөхөн үйлдвэрлэл, сүргийн эргэлтийн баланс, малын ашиг шимийн бүтээгдэхүүн	1	
Аж үйлдвэр	Аж үйлдвэрийн салбарын ангилал, ойлголт, ажиглалтын нэгж, тэдгээрийн тодорхойлолт, аж үйлдвэрийн газрын нийт үйлдвэрлэл, нэмэгдэл өртөг, завсрын хэрэглээг тодорхойлох	1	
	Аж үйлдвэрийн газрын машин, тоног төхөөрөмжийн статистик, Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний зардал (өөрийн өртөг) -ын статистик, аж үйлдвэрийн санхүүгийн үр дүнгийн статистик	1	1
Барилга, тээврийн статистик	Барилга, тээвэр, холбоо, худалдааны салбарын нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн статистик үзүүлэлтүүд	2	1
Нийт		7	3

Модуль 6: Хүн ам, нийгмийн статистик			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Хүн ам	Хүн амын тоо бүрэлдэхүүн, ердийн ба механик хөдөлгөөний статистик	1	1
	Нийгмийн статистикийн эх үүсвэр ба хэрэглээ	1	

Хөдөлмөрийн зах зээл	Хөдөлмөрийн зах зээлийн статистик, хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсний статистик	1	1
Хүний хөгжлийн статистик	Хүний хөгжлийн үзэл баримтлал, хэмжигдэхүүн, хүний хөгжлийн индекс тооцох	1	1
Ядуурлын статистик	ДНБ-ий хэрэглээ, хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын статистикийн үзүүлэлтүүд	2	
Нийт		6	3

Модуль 7: Статистикийн хэрэглээний программ I			
Сэдэв	Агуулга	Судлах цаг	
		Сургалтаар	Бие даалт
Удиртгал	MS Excel программын талаарх ойлголт, ачаалах, программын бүтэц	2	2
MS Excel программ	MS Excel программын нийтлэг хэрэглэгддэг функцуудыг судлах	2	2
Регрессийн шинжилгээ хийх	Регрессийн шинжилгээний талаарх ойлголт, MS Excel программд регрессийн шинжилгээг хийх, үр дүнг тайлбарлах	2	1
